



МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

Огноо: 2010/08/09/

Дугаар: 274

Улаанбаатар хот

Эрүүл зан үйл төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны үндэсний стратегийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.7.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Эрүүл зан үйл төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны үндэсний стратеги”-ийг нэгдүгээр, “Эрүүл зан үйл төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны үндэсний стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдамж”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. “Эрүүл зан үйл төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны үндэсний стратеги”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний түвшинд зохион байгуулан, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар (Ц.Содномпил), орон нутгийн түвшинд зохион байгуулан, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
3. Үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж, олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжийг чиглүүлэх арга хэмжээ авахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Н.Түмэндэмбэрэл), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.
4. “Эрүүл зан үйл төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны үндэсний стратеги”-ийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн үнэлгээг жил бүрийн 12 сарын 15-ны дотор хийж, Удирдлагын зөвлөлд танилцуулж байхыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Эрүүл мэндийн газар (Ц.Содномпил)-т даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Төгсдэлгэр)-т даалгасугай.
6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2002 оны 311, Эрүүл мэндийн сайдын 2008 оны 211 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

С.ЛАМБАА

Нэг. Стратеги боловсруулах үндэслэл

Сүүлийн 5 жилийн хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтээс харахад өвчлөл нас баралтын шалтгаанд халдварт бус өвчин (ХБӨ) давамгайлж, тасралтгүй нэмэгдсээр байна. Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгааныг цусны эргэлтийн тогтолцооны өвчин, хавдар, бэртэл хордлого гадны шалтгаант үр дагавар, хоол шингээх эрхтэний өвчин болон амьсгалын тогтолцооны эмгэг эзэлж байна.

Үүнээс гадна халдварт өвчний тархалт нийт улсын хэмжээнд буурахгүй байгаа төдийгүй шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний гаралт нэмэгдэж байна. 2009 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт халдварт өвчний 43.8% бэлгийн замаар дамжих халдвар, 17.70% вируст гепатит, 10.8% сүрьеэ, 9.4% гэдэсний халдварт өвчин эзэлж байна.

Зонхилон тохиолдож байгаа халдварт болон халдварт бус өвчий шалтгаан нь хувь хүний амьдрах хэв маяг, зан үйлээс 50%, гадаад орчноос 25%, удамшлаас 15%, эрүүл мэндийн үйлчилгээнээс 10% хамаардаг гэж ДЭМБ үздэг.

Хүн амын дунд эрүүл бус хоол хүнсний хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, тамхидалт, архины зохисгүй хэрэглээ, бухимдлаа буруу тайлах, хувийн ариун цэвэр сахидаггүй байдал газар авсан нь зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчин нэмэгдэхэд нөлөөлж байна.

Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгаа (МСС)-ны үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор “Хүн амын эрүүл мэндийн боловсрол үндэсний хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 5 дугаар тогтоол, “Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоол, “Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх тухай” Эрүүл мэндийн сайдын 2002 оны 311 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд багагүй ололт, амжилт, туршлага, сургамж хуримтлагдсан. Тухайлбал, аймаг, нийслэлд эрүүл зан үйл төлөвшүүлэх МСС-г зохион байгуулах хүний нөөц бий болж, мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалын загвар, агуулга, төрөл, хэлбэр олширч, сурталчилгааны суваг өргөжсөн.

Гэвч эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа нь зорилтот бүлэгт чиглэгдээгүй, зан үйлийг өөрчлөх онолд тулгуурлаагүй, зан үйлийн судалгаа хомс, судалгааны үр дүнг үйл ажиллагаанд ашиглах, олон нийтэд мэдээлэх нь хязгаарлагдмал, боловсруулсан МСС-ны материалыг алслагдсан хүн амд хүргэх тогтолцоогүй, хүний нөөц дутмаг, чадавхи сул, санхүүжилт дутмаг, эрүүл мэндийн боловсрол олгодог байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо хангалтгүй зэрэг асуудлууд гарч байна.

Мөн эмч, эмнэлгийн ажилчид өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэхээс илүүтэйгээр эмчилгээг чухал гэж үзэх хандлагатайгаас үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгөх, МССявуулах үйл ажиллагаанд анхаарлаа хандуулдаггүй.

Олсон ололт амжилт, сургамжаас харахад, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бий болгох МСС-ны талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлого, арга хэмжээний нэгдсэн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт, хяналт үнэлгээ, санхүүжилтийн тогтолцоо үгүйлэгдэж байна.

Иймээс Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий сайдын 2010 онд баталсан Эрүүл мэндийн салбарт хийх цогц шинэчлэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Эрүүл мэндийн салбарын Мастер төлөвлөгөөний “Хүн амын зан үйлийг өөрчлөх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх улмаар зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчнийг бууруулахад чиглэсэн МСС-ны үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах” зорилтын хүрээнд заасны дагуу “Хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны үндэсний стратеги”-ийг боловсруулав.

Хоёр. Стратегийн зорилго, зорилт, хүлээгдэж буй үр дүн, үйл ажиллагааны чиглэл.

2.1 Стратегийн зорилго:

Хүн амд эрсдэлт зан үйлээ өөрчлөх, эрүүл зан үйл төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулах

2.2 Зорилтууд, хүлээгдэж буй үр дүн.

Зорилт 1

Эрүүл зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл 1

Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт хүн чиглэсэн ухуулга, нөлөөллийн үйл ажиллагаа идэвхжүүлэх, төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр:

Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарын дэмжлэгийг авах ухуулга нөлөөллийн үйл ажиллагааг өрнүүлэх замаар орон нутгийн засаг захиргаа, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, үндсэн чиглэл, ажил үүргийн хуваарьт нь эрүүл зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх асуудлыг тусган, тэдгээрийн дэмжлэг, оролцоог нэмэгдүүлнэ.

Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлэх, ололт амжилтаа хуваалцах үйл ажиллагаанд төрийн ба төрийн бус байгууллага, хэвлэл, мэдээллийн байгууллага, аж ахуйн нэгж, олон нийт,

гэр бүл, иргэдийн оролцоог ханган, нөөцийг дайчлах замаар тэдний санал санаачилгыг өрнүүлж, эрүүл мэндийнхээ төлөө зөв шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлнэ.

Алслагдмал нутаг дэвсгэрт амьдарч буй болон хүн амын эмзэг бүлэгт эрүүл зан үйл төлөвшүүлэх МСС явуулахад олон нийт, иргэний нийгэм, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэд, сайн дурын идэвхтнийг татан оролцуулж, тэднийг чадавхижуулна.

Эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр ажиллаж байгаа хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр:

Хүний нөөцийн хүртээмж, ур чадвар, туршлага хангалтгүй байгаа нь эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг чанартай, хүртээмжтэй хүргэхэд нөлөөлж байна. Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан нийгмийн ажилтан, цэцэрлэг, сургуулийн эмч, арга зүйч нарын ажлын байрны тодорхойлолтод үнэлгээ өгч, шинэчлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах хөшүүрэг бий болгоход чиглэсэн арга хэмжээ авна

Эмч, эмнэлгийн ажилтнуудад өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, эрт оношлохын ач холбогдол, үйлчлүүлэгчидтэй харилцах харилцаа болон эрүүл зан үйл төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг зан үйлийн өөрчлөлтийн онолтой уялдуулан төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. Мөн сургагч багш, сайн дурын идэвхтэн бэлтгэн, чадавхижуулах замаар хүний нөөцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйл төлөвшүүлэхэд ашиглах МСС-ны багц болон сургалтын хэрэглэгдэхүүнээр хангана. .

Хүлээгдэж буй үр дүн 1

- Эрүүл зан үйл төлөвшүүлэх салбар хоорондын хамтын ажиллагаа үндэсний болон орон нутгийн түвшинд өргөжнө.
- Эрүүл зан үйл төлөвшүүлэх үйл ажиллагаанд олон нийт, шийдвэр гаргагчдын оролцоо, дэмжлэг нэмэгдэнэ.
- Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх эрх зүй болон нийгмийн дэмжлэгт орчин бүрдэнэ.
- Эрүүл зан үйл төлөвшүүлэх үйл ажиллагаанд зарцуулах санхүүжилт нэмэгдэнэ.
- Судалгаа нотолгоонд суурилсан эрүүл зан үйлийг төлөвшүүлэх МСС-ны үйл ажиллагаа өргөжнө.
- МСС-ны материалын чанар хүртээмж сайжирна.
- Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх МСС-г зохион байгуулах эмч, эмнэлгийн ажилтан, сайн дурынхны чадавхи нэмэгдэнэ.

Зорилт 2

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл зан үйл төлөвшүүлэх МСС-г эрчимжүүлэх;

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл 2

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Хүүхдэд хувийн ариун цэвэр сахих зан үйлийг цэцэрлэг, ясли, сургуулийн багш, эмч нар, эцэг, эхээр дамжуулан, бодит үзүүлэн материал ашиглан төлөвшүүлнэ.

Хүүхдээ дархлаажуулалтанд хугацаанд нь хамруулах талаар жирэмсэн эхчүүдэд жирэмсний хяналтад байхад нь, төрсөн эхчүүдэд төрөөд эмнэлгээс гарахад нь эмч, эмнэлгийн ажилчдаар зөвлөгөө өгүүлж, мөн дархлаажуулалтын талаарх хэвлэмэл материалыг эцэг, эхчүүдэд түгээнэ.

Шинээр болон дахин сэргэж буй халдварын талаарх үнэн зөв мэдээллийг цаг тухайд нь ОНМХ-ээр шуурхай хүргэнэ. Мөн дэлгүүр, нийтийн тээврийн хэрэгсэл, автобусны буудал, үйлчилгээний газруудаар мэдээлэл хүргэнэ.

Мал төллөх үеэр малчид, мал аж ахуйн мэргэжилтнүүдэд малаас хүнд дамжих халдвараас сэргийлэх талаарх мэдээллийг телевиз, радио, сонин, гар утас, хэвлэмэл материалаар дамжуулан хүргэнэ.

БЗДХ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Өсвөр насны охид, хөвгүүдэд шохоорхол, үерхэл, хайр, эрт бэлгийн харьцаанд орохгүй байх, өсвөр насанд жирэмслэх, үр хөндүүлэхийн хор холбогдлын талаарх мэдээллийг тэдний хүсэл сонирхолд нийцүүлэн үе тэнгийн сургагч, урлаг, спортын одууд, эрүүл мэндийн сурах бичиг, хөгжмийн суваг, комикс ном, кино театр, “Өсвөр үе”, НҮЭМ-ийн кабинетаар дамжуулан хүргэнэ.

Бэлгийн идэвхитэй амьдралтай хүмүүс, хөдөлгөөнт хүн амд тохиолдлын бэлгийн хавьтлыг тэвчих, гэр бүлийн хосуудад бие биедээ үнэнч байх мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, МСС-ны материалаар хүргэнэ.

Биеэ үнэлэгчид, БЗДХ-ын кабинетаар үйлчлүүлэгч нарт тохиолдлын бэлгийн хавьталд орох бүртээ бэлгэвчийг зааврын дагуу зөв хэрэглэх, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, эмнэлэгт эрт хандах мэдээллийг бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага, зөвлөгөө өгөх хэлбэрээр эрүүл мэндийн ажилтан, сайн дурын идэвхтнээр дамжуулан хүргэнэ.

Нийт хүн амд гоо сайхны мэс ажилбар хийлгэх, чих цоолуулах, шүд эмчлүүлэх, жижиг мэс ажилбар хийлгэхдээ эрүүл ахуйн шаардлага хангасан, найдвартай газраар үйлчлүүлэх, шаардлагагүй тарилгаас зайлсхийхийг сурталчлан таниулах МСС-г явуулна.

Эрүүл мэндийн ажилтнуудыг эрсдэлт бүлгийн хүмүүст ганцаарчилсан зөвлөгөө өгөх чиглэлээр сургана.

Орчны бохирдолтой холбоотой эрсдэлт зан үйлийг өөрчлөх чиглэлээр:

Хүүхдэд бага наснаас нь байгаль орчноо хамгаалах, хогийг зориулалтын саванд хаях, ил задгай бие засахгүй байх, гудамж зам талбайг цэвэрхэн байлгах, амьдарч буй гадаад орчноо цэвэр байлгах зан үйлийг цэцэрлэг, ясли, сургуулийн багш, эмч нар, эцэг, эх, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтнаар дамжуулан бодит үзүүлэн материал ашиглан төлөвшүүлнэ.

Түүхий ус уухгүй байх, ундны ус хадгалах, зөөвөрлөх, савыг зөв сонгох, гэрийн нөхцөлд усыг зөв хадгалах мэдээллийг нийт хүн амд хүргэнэ.

Хүлээгдэж буй үр дүн 2

- Дархлаажуулалтын хамралт өндөр түвшинд хадгалагдана.
- Тарилгат халдварт өвчний гаралт буурна.
- БЗДХ-ийн тархалт эмзэг бүлгийн хүн амын дунд буурна.
- БЗДХ-ийн халдварын шинж тэмдэг илэрсэн залуучуудын эмнэлэгт хандалт нэмэгдэнэ.
- Гэдэсний халдварт өвчний гаралт буурна.

Зорилт 3

Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл зан үйлийг төлөвшүүлэх МСС-г эрчимжүүлэх;

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл 3

Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Эрүүл хоол, хүнс сонгох, зөв хадгалах, жимс, хүнсний ногоо түлхүү хэрэглэх, эрүүл зохисой хооллох дэглэм баримтлах зан үйлийг хүүхдэд цэцэрлэг, ясли, сургуулийн багш, эцэг, эх, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтнаар дамжуулан жишээ, баримт, бодит үзүүлэн материал ашиглан төлөвшүүлнэ.

15-64 насныханд хоолны цэсэндээ амьтны гаралтай өөх тос, давс багатай, эрүүл хоолны жор оруулах, хот, хөдөөд жимс жимсгэнэ, төмс, хүнсний ногоог өөрсдөө тарьж хэрэглэх тухай мэдээллийг интернет, гар утас, сонин, сэтгүүл, телевиз, хэвлэмэл материалаар дамжуулан хүргэнэ.

Тогтмол дасгал, хөдөлгөөн хийх, биеийн жингээ хэвийн хэмжээнд барихын ач холбогдлын талаарх мэдээллийг МСС-ны бүхий л боломжит суваг, арга хэлбэрээр нийт хүн амд хүргэнэ. Энэ үйл ажиллагааг 15-24 насны залуучууд болон 35 –аас дээш насны суугаа хөдөлмөр эрхлэгчдэд түлхүү чиглүүлнэ.

15-24 насны залуучууд, 35-54 насны эмэгтэйчүүд, 25-54 насны эрэгтэйчүүдэд архины хор уршиг, архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх талаарх мэдээллийн эрүүл мэндийн хичээл, ажлын байраар дамжуулан хүргэнэ.

Хүүхэд, залуучуудад тамхины хор холбогдлын талаарх мэдээллийг урлаг, спортын одод, хөгжмийн суваг, комикс ном, кино театр, интернет, концерт, хошин шогийн тоглолт, сургуулиудын танилцах өдөрлөгөөр дамжуулан хүргэнэ. Гэр бүл, хамт олон, олон нийтийн газар бусдын дэргэд тамхи татахгүй байх талаарх мэдээллийг нийт хүн амд МСС-ны бүхий л суваг, арга хэлбэрээр хүргэнэ.

Нийт хүн амд бухимдлыг архи, тамхиар бус, өөрийгөө тайвшруулах, сэтгэлээ амгалан байлгах аргаар тайлах мэдээллийг нийгмийн ажилтан, бясалгалын төв, төрийн

бус байгууллага, шашны байгууллагаар дамжуулан, МСС-ны боломжит бүхий л сувгаар хүргэнэ.

Хүүхэд, залуучуудад компьютер тоглоомын хор уршгийн талаарх мэдээллийг интернет, гар утас, эрүүл мэндийн хичээл, үе тэнгийн сургагчаар дамжуулан МСС-г зохион байгуулна.

Настны сэтгэл гутралаас сэргийлэх мэдээллийг мэргэжлийн байгууллагатай хамтран баг, хорооны дэргэд сайн дурын бүлгэм, баг байгуулах замаар хүргэнэ.

Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлээр:

Замын хөдөлгөөний дүрмийн талаарх мэдлэгийг хот, суурингийн цэцэрлэг, ясли, сургуулийн багш, эцэг, эх, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтан, замын цагдаагаар дамжуулан хүүхдэд жишээ, баримт, бодит үзүүлэн материал ашиглан олгоно.

Нийт хүн амд замын хөдөлгөөнд оролцохдоо замын хөдөлгөөний дүрмийг баримтлах талаарх мэдээллийг хэвлэмэл материал, ФМ радио, телевиз, өдөр тутмын сониноор дамжуулан хүргэхийг хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаатай хослуулан хэрэгжүүлнэ.

Зам тээврийн осол хамгийн их гардаг хар цэгийг тогтоон, замын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч, МСС-ны үйл ажиллагааг зохион байгуулна.

Цэцэрлэг, ясли, сургуулийн багш, эцэг, эх, асран хамгаалагч нарт бага насны хүүхдийг түлэгдэлт болон ахуйн осол гэмтлээс сэргийлэх мэдлэг олгох МСС-г бүх суваг, арга хэлбэрээр зохион байгуулна.

Хүлээгдэж буй үр дүн 3

- Насанд хүрэгчдийн дунд архи, тамхины хэрэглээ буурна.
- Хүн амын жимс, хүнсний ногооны хэрэглээ нэмэгдэнэ.
- Дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэгсэд нэмэгдэнэ.
- Зам тээврийн осол гэмтэл буурна.
- Бага насны хүүхдийн түлэгдэлт, ахуйн осол гэмтэл буурна.

Зорилт 4

НҮЭМ-ийн эрүүл зан үйлийг төлөвшүүлэх МСС-г эрчимжүүлэх;

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл 4

Жирэмсний хяналтад эрт орох, эх нярайд илэрч болох аюултай шинжийг мэдэх, түүнээс урьдчилан сэргийлэх, жирэмслэлтэд бэлтгэх, гэр бүл төлөвлөлтийн үр дүнтэй аргуудыг хэрэглэж сурах талаарх мэдээллийг нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн болон нийгмийн ажилтан, сайн дурын идэвхтнээр дамжуулан хэвлэмэл материал, үзүүлэн материал ашиглан хүргэнэ.

Нийт эмэгтэйчүүдэд умайн хүзүүний хавдраас урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол орох, хөхөө өөрөө шалгах аргыг эзэмшүүлэх МСС-г анхан шатны эмнэлгийн ажилтан, нийгмийн ажилтан, сайн дурын идэвхтнээр дамжуулан явуулна.

Хүлээгдэж буй үр дүн 4

- Өсвөр насныхны жирэмслэлт буурна.
- Үр хөндөлт буурна.
- Жирэмсний хяналтад эрт орох хувь нэмэгдэнэ.

Гурав. Стратегийг хэрэгжүүлэх зарчим.

Хүн амд эрүүл зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэхэд дараах зарчмыг баримтлана:

1. Тухайн орон нутаг, байгууллага хамт олны зонхилон тохиолдож байгаа халдварт болон халдварт бус өвчинд хүргэж буй эрсдэлт хүчин зүйлс, эрсдэлт зан үйлд дүн шинжилгээ хийж, зорилтот бүлгийн өвөрмөц эрэлт хэрэгцээнд тохирсон үйл ажиллагаа явуулах;
2. Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх гол мэдээллийг МСС-ны бүхий л боломжит тохирсон суваг, арга хэлбэрээр, үе шаттайгаар, тасралтгүй, цуврал хэлбэрээр явуулах;
3. Мэдээлэл, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулахдаа хувь хүний хандлага, итгэл үнэмшил, идэвх зүтгэл, нийгэм, эдийн засгийн хүчин зүйл, нас хүйс, сэтгэлзүй, удамзүйн онцлогт тулгуурлах;
4. Хүйсийн тэгш байдлыг хангах.

Дөрөв. Стратегийн хэрэгжилтийн удирдлага, зохион байгуулалт.

Үндэсний түвшинд:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар (цаашид ЭМГ гэх) хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх МСС-ны стратегийн хэрэгжилтийг орон даяар зохион байгуулах, байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, зөвлөгөө өгөх, хянах, үр дүнг тооцох үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

Эрүүл мэндийн газар нь МСС-ны материалыг орон нутагт шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэх, хэрэгцээг судлах асуудлыг үндэсний хэмжээнд зохицуулж, МСС-ны материалын мэдээний санг байгуулж, тогтмол шинэчилнэ.

Үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжиж буй олон улсын болон дотоодын төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа МСС-ны материалын агуулгыг ЭМГ-ын Эрүүл

мэндийг дэмжих хэлтсээр хянуулж, МСС-ны нэгдсэн мэдээний сангийн шалгуур хангасан МСС-ны материалыг тус нэгдсэн санд байршуулна.

Орон нутгийн түвшинд:

Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх МСС-ны стратегийн хэрэгжилтийг орон нутгийн түвшинд мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган, бусад хөтөлбөр төсөлтэй уялдуулан зохицуулна.

Тус стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахдаа зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчинд хүргэж байгаа эрсдэлт хүчин зүйл, эрсдэлт зан үйл, зорилтот бүлэг, мэдээллийн суваг зэргийг тодорхойлон, МСС-ны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.

Орон нутгийн Эрүүл мэндийн байгууллага МСС-ны материал боловсруулах шаардлагатай бол МСС-ны материалын агуулгыг МСС-ны нэгдсэн сангаас авч ашиглана.

Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь МСС-ны материалыг сум, дүүрэг, баг, хороонд шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэх асуудлыг орон нутгийн хэмжээнд зохицуулж, эрүүл зан үйл төлөвшүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэнд орон нутгийн байгууллага, хамт олон, хувь хүнийг татан оролцуулна.

Тав. Стратегийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

5.1 Хэрэгжүүлэх хугацаа:

Стратегийг 2010 -2016 онд хэрэгжүүлнэ.

5.2 Санхүүжилт:

1. Улсын болон орон нутгийн төсөв
2. Эрүүл мэндийг дэмжих сан
3. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр
4. Хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр

Зургаа. Стратегийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, шалгуур үзүүлэлтүүд

6.1 Үндэсний хэмжээнд:

Хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх МСС стратегийн хэрэгжилтийн дотоод болон хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээг ЭМГ шаардлагатай бол бусад байгууллагатай хамтран зохион байгуулна.

Стратегийн хэрэгжилтийн явцын хяналтыг стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийг ашиглан МСС-ны үйл ажиллагааны хэлбэр, цар хүрээ, материалын тоо, төрөл, хүртээмж, түгээсэн байдлыг тооцон явуулна.

Стратегийн хэрэгжилтийн явцын хяналтын үр дүнг ашиглан стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэх, боловсронгуй болгох ажлыг ЗГХА-ЭМГ зохион байгуулна.

Дунд хугацааны үнэлгээнд 2013 онд ДЭМБ болон Монголын мянганы сорилтын сангийн Эрүүл мэндийн төслийн хүрээнд зохион байгуулах “Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтын судалгаа”-ны үр дүнг ашиглана.

Стратегийн эцсийн үнэлгээг 2016 онд ЭМГ зохион байгуулна.

6.2 Орон нутгийн түвшинд:

Орон нутгийн түвшинд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь тухайн орон нутгийн онцлогт тохируулан боловсруулсан стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийг ашиглан явцын хяналтыг тавина.

6.3 Стратегийн хэрэгжилтийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2009 оны суурь түвшин	2016 оны зорилтот түвшин	Эх сурвалж
15-64 насны хүмүүсийн дунд одоогоор тамхи татдаг хүмүүсийн хувь	27.6	24.5	“ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлийн тархалтын судалгаа”, 2009
15-64 насны хүмүүсийн дунд сүүлийн 30 хоногт архи хэрэглэсэн хувь	38.6	30.0	“ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлийн тархалтын судалгаа”, 2009
15-64 насны хүмүүсийн дунд таргалалттай хүмүүсийн хувь	39.8	37.0	“ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлийн тархалтын судалгаа”, 2009
Замын хөдөлгөөний дүрмийн холбогдох заалтын мэдлэг хангалтгүй явган зорчигчийн хувь	66	55	“Явган зорчигч, жолооч, замын цагдаагийн замын аюулгүй байдалтай холбоотой мэдлэг, дадал, хандлагын судалгаа, 2010
Замын хөдөлгөөний дүрмийн холбогдох заалтын мэдлэг хангалтгүй жолоочийн хувь	46	35	Явган зорчигч, жолооч, замын цагдаагийн замын аюулгүй байдалтай холбоотой мэдлэг, дадал, хандлагын судалгаа, 2010
15-24 насны залуусын сүүлийн тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн хувь	51.4	80.0	Харуулдан тандалтын судалгаа, 2007 он
15-19 насны охидын хүүхэд төрүүлсэн хувь	8.2	7.4	НҮЭМ-ийн судалгаа, 2008он
Жирэмсний эрт хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь	83.2	85.2	Эрүүл мэндийн статистик үзүүлэлт, 2009

Эрүүл мэндийн сайдын 2010 оны
8 дугаар сарын 9-ний өдрийн
274 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ ЗАН ҮЙЛ ТӨЛӨВШҮҮЛЭХ МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАМЖ

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл зан үйлийг төлөвшүүлэх МСС-г эрчимжүүлэх Зорилт 2-ын хүрээнд:						
Төлөвшүүлэх эрүүл зан үйл	Шалгуур үзүүлэлтүүд	Зорилтот бүлэг	Хүргэх гол мэдээлэл	Хүргэх суваг	Хүргэх хэлбэр	Хүргэх хүн
Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:						
Гараа зөв угаах	Гэдэсний халдварт өвчний гаралтын тоо Гар угаах талаар мэдээлэл авсан хүүхдийн тоо	<ul style="list-style-type: none"> Бага насны хүүхдүүд Эцэг эх, ах эгч Цэцэрлэг, ясли, сургуулийн багш, эмч нар 	<ul style="list-style-type: none"> Хоол идэхээс өмнө, гадаа тоглосны дараа, бохирдсон үед гараа зөв, савандаж угаах 	<ul style="list-style-type: none"> Цэцэрлэг, ясли, сургууль, гэрийн орчин Сургалтын материал Сургалт 	<ul style="list-style-type: none"> Бодит үзүүлэн материал Жүжигчилсэн тоглолт Хүүхэлдэйн кино Комикс 	<ul style="list-style-type: none"> Эцэг эх, ах эгч Цэцэрлэг, ясли, сургуулийн багш, эмч нар Бишрэн шүтдэг жүжигчин, дуучин
Амны хөндийн ариун цэврийг тогтмол сахих	Шүд угаах ач холбогдлын талаар мэдээлэл авсан хүүхдийн тоо Шүдээ тогтмол угаадаг хүүхдүүдийн тоо	<ul style="list-style-type: none"> Бага насны хүүхдүүд Эцэг эх, ах эгч Цэцэрлэг, ясли, сургуулийн багш, эмч нар 	<ul style="list-style-type: none"> Хоол идсний дараа, өглөө, унтахаас өмнө шүдээ тогтмол угаах Шүдний эмчид сар, улирал тутам очиж, урьдчилан сэргийлэх үзлэгт орох 	<ul style="list-style-type: none"> Цэцэрлэг, ясли, сургууль, гэрийн орчин Сургалтын материал Сургалт Шүдний кабинет 	<ul style="list-style-type: none"> Бодит үзүүлэн материал Жүжигчилсэн тоглолт Хүүхэлдэйн кино Комикс 	<ul style="list-style-type: none"> Эцэг эх, ах эгч Цэцэрлэг, ясли, сургуулийн багш, эмч нар Бишрэн шүтдэг жүжигчин, дуучин Шүдний эмч
Дархлаажуулалтад хамруулах	Дархлаажуулалтын хамралтын түвшин Вакцины дараах урвал, хүндрэлийг мэддэг эхчүүдийн тоо	<ul style="list-style-type: none"> Жирэмсэн эх Төрсөн эх 	<ul style="list-style-type: none"> Товлолын дагуу хүүхдээ вакцинд бүрэн хамруулах 	<ul style="list-style-type: none"> Жирэмсний хяналтад байхад Төрөх газар Өрх, сумын эмнэлэг Сурталчилгааны материал 	<ul style="list-style-type: none"> Зөвөлгөө өгөх Санамж 	<ul style="list-style-type: none"> Эмч, эмнэлгийн ажилтан Дархлаажуулалтын ажилтан

Малаас хүнд халддаг халдвараас сэргийлэх	Бруцеллёз өвчлөлийн түвшин Малаа жил бүр бруцеллёзын вакцинд хамруулахын ач холбогдлыг мэддэг малчид, мал аж ахуй мэргэжилтнүүдийн тоо	<ul style="list-style-type: none"> • Малчид • Мал аж ахуйн мэргэжилтнүүд <ul style="list-style-type: none"> • тэдний гэр бүл 	<ul style="list-style-type: none"> • Малаа жил бүр бруцеллёзын вакцинд хамруулах • Төл хүлээн авах, бэрхшээсэн төл гардах, арьс шир бэлтгэх, мал саах, ноослох, хэрэгцээлэх, өтөг бууц цэвэрлэхдээ амны хаалт, хормогч, резинэн бээлий өмсөх • Мал, амьтаны гаралтай бүтээгдэхүүнийг сайтар боловсруулж чанаж хэрэглэх • Үхсэн мал, амьтны арьс, үс, махыг ашиглахаас татгалзах 	<ul style="list-style-type: none"> • Мал эмнэлэг • Ажлын байр • Сурталчилгааны материал 	<ul style="list-style-type: none"> • Гарын авлага • Зурагт хуудас • Зөвлөмж • Сургалт 	<ul style="list-style-type: none"> • Үе тэнгийн сургагч, • Мэргэжлийн эмч, сувилагч багш • Сайн дурын идэвхтэн • Нийгмийн ажилтан • Их дээд сургуулийн дадлагын оюутан
БЗДХ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх чиглэлээр:						
Эрт бэлгийн харьцаанд орохгүй байх	Өсвөр үеийнхний анх бэлгийн харьцаанд орж буй нас	<ul style="list-style-type: none"> • Охид • Хөвгүүд • Эцэг эх, • асран 	<ul style="list-style-type: none"> • "Үгүй" гэж хэлж сурах • Эрт бэлгийн харьцаанд 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн хичээл • Интернэт • Өсвөр 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн сурах бичиг • Санамж • Зурагт хуудас 	<ul style="list-style-type: none"> • Сайн дурын идэвхтэн • Урлаг, спортын одод

	Охидын жирэмслэлтийн хувь Үр хөндөлтийн хувь Охидын төрөлтийн хувь	хамгаалагч • Багш • Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид	орохгүй байх • Бэлгийн харьцаанд орохгүйгээр хайр сэтгэлээ илэрхийлж сурах • Өсвөр насандаа жирэмслэхгүй байх	үеийнхний хэрэглэдэг хэрэглээний материалууд • Комикс • Өсвөр үеийнхний сонирхдог ном, сэтгүүл • НҮЭМ-ийн кабинет • Өсвөр үеийнхэнд зөвлөгөө өгөх төвүүд	• Ганцаарчилсан зөвлөгөө • Ярилцлага, хэлэлцүүлэг • Сургалт • Мэтгэлцээн • Клиптэй дуу • Сургамжит зохиол бүтээл /кино, жүжиг, шоу тоглолт/	• Нийгмийн ажилтан • Үе тэнгийн сургагч • НҮЭМ-ийн кабинетийн эмч • Өсвөр үеийн эмч
Тохиолдлын бэлгийн хавьтлыг тэвчих	Зөвөлгөө авсан иргэдийн тоо Нэгээс олон бэлгийн хавьтагчтай хүний тоо	• Бэлгийн идэвхитэй амьдралтай хүмүүс • Хөдөлгөөнт хүн ам	• Тохиолдлын бэлгийн хавьтлыг тэвчих • Гэр бүлийн хосууд бие биедээ үнэнч байх.	• Сурталчилгааны материал • НҮЭМ –ийн кабинетүүд • Интернет • Зочид буудал • Баар, цэнгээний газар	• Санамж • Ганцаарчилсан зөвлөгөө • Зурагт хуудас • Ярилцлага • Сургамжит зохиол бүтээл /кино, жүжиг, шоу тоглолт/ • Мэдээлэл өгөх үнэгүй утасны шугам	• Сайн дурын идэвхтэн • НҮЭМ-ийн кабинетийн эмч • Эрүүл мэндийн ажилтан • Үе тэнгийн сургагч
Бэлгэвч хэрэглэх	БЗДХ-тай гэж оношлогдоод эмчлүүлсэн биеэ үнэлэгчдийн тоо Сүүлийн 3 сарын дотор үйлчлүүлэгчтэйгээ бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн биеэ үнэлэгчдийн тоо	• Биеэ үнэлэгчид, БЗДХ-ын кабинетаар үйлчлүүлэгч	• Тохиолдлын бэлгийн хавьталд орох бүртээ бэлгэвчийг зааврын дагуу зөв хэрэглэх • Хамгаалалтгүй бэлгийн хавьталд орсон бол ямар нэг шинж тэмдэг илрэхийг	• Сайн дурын зөвлөгөө шинжилгээний төвүүд • НҮЭМ-ийн кабинет • Зочид буудал • Баар цэнгээний газар	• Санамж • Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага • Зөвлөгөө • Сургамжит зохиол бүтээл /кино, жүжиг, шоу тоглолт/ • Мэдээлэл өгөх	• Эрүүл мэндийн ажилтан • Сайн дурын идэвхтэн • Үе тэнгийн сургагч • Цагдаа • Зочид буудал, баарны ажилтан

	Эрчүүдтэй бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч тогтмол хэрэглэдэг эрчүүдийн тоо		хүлээлгүй эмнэлэгт эрт хандах		үнэгүй утасны шугам	
Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл зан үйлийг төлөвшүүлэх МСС-г эрчимжүүлэх Зорилт 3-ын хүрээнд:						
Хүнсний бүтээгдэхүү нийг зохистой хэрэглэх	Хот, хөдөөд жимс, жимсгэнэ, төмс хүнсний ногоог өөрсдөө тарьж хэрэглэдэг өрхийн тоо Хоолны цэсэндээ амьтны гаралтай өөх тос, давс багатай эрүүл хоолны жор оруулдаг өрхийн тоо	<ul style="list-style-type: none"> • 15-64 насныханд 	<ul style="list-style-type: none"> • Малын өөх-тос, давс, элсэн чихэр, чихэрийн хэрэглээг багасгах • Жимс, хүнсний ногоо, ширхэглэг, үр тарианы хүнсний бүтээгдэхүүн түлхүү хэрэглэх • Хоолны цэсэндээ амьтны гаралтай өөх тос, давс багатай эрүүл хоолны жор оруулах • Хот, хөдөөд жимс, жимсгэнэ, төмс хүнсний ногоог өөрсдөө тарьж хэрэглэх • хэт их идэхгүй байх, хуурсан, шарсан, нөөшилсөн хоол, хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг багасгах • хоол, цайг хэт халуун хэрэглэхгүй байх 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн хичээл • Гэрийн эзэгтэй нарын сургалт • Телевиз, радио, • Сонин, сэтгүүл • Товхимол • www.hool.mn • Сурталчилгааны материал • Цагаан хоолны төв • Ажлын байр • Гэрийн эзэгтэй нар 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн сурах бичг • Гэрийн эзэгтэй нараас үе тэнгийн сургагч бэлтгэх • Мэргэжилтний зөвлөгөө • Бусдын туршлагыг яриулах • Цуврал нэвтрүүлэг • Ажлын байр дахь сургалт • Асуулт хариултын булан • “Дэвжээ” “АХА” • Санамж • Зурагт хуудас 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн багш • Гэрийн эзэгтэй нар • Эрүүл мэндийн ажилтан • Бахархан дуурайдаг хүмүүс • Хэвлэл мэдээллийнхэн • Сайн дурын идэвхтэн • Зоогийн газрын зөөгчид • Зохистой хооллолтын төвийн зөвлөгөө өгөгчид
		Шийдвэр	• Эрүүл хоол,	• Ажлын байр	• Ухуулга	• Эрүүл мэндийн

		гаргагчдад	хүнсээр хангах орчин бүрдүүлэх	• Сурталчилгааны материал	сурталчилгаа • Баримтын цомог	ажилтан • Хамт олон
Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх	Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх сонирхолтой хүний тоо Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэж эхэлсэн хүний тоо Ажлын байрандаа дасгал хөдөлгөөнийг дэмжих орчин бүрдүүлсэн байгууллагын тоо	<ul style="list-style-type: none"> • 15-24 насны залуучууд • 35-аас дээш насны суугаа хөдөлмөр эрхлэгчид 	<ul style="list-style-type: none"> • Хүн бүр өдөр тутам наад зах нь 30 минут шаламгай алхах, дугуйгаар явах • Цэцэрлэг, сургууль, хамт олны дунд өдрийн завсарлагаар идэвхитэй хөдөлгөөн, дасгал хийх • Биеийн жингээ тогтмол хэмжээнд барихын тулд өдөрт наад зах нь 1 цаг хүч тэнхээ шаардсан биеийн тамирын дасгал, хөдөлгөөнөөр хичээллэх • Хүүхэд, залуучууд нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэх дасгалыг долоо хоногт 3 удаа, 20 минутаас доошгүй хугацаагаар хийх. 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн хичээл • Телевиз, радио • Интернет • Гар утас • Сэтгүүл • Комикс • Ажлын байр • Фитнесс, боди клубууд, • Зарлалын LED дэлгэц, • Кино театр <p>Эрүүл мэндийн өдөрлөг</p> <ul style="list-style-type: none"> • Сурталчилгааны материал 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн сурах бичиг • Хөгжөөнт нэвтрүүлэг, • Хэлэлцүүлэг • Бусдын туршлагыг яриулах • Реалити шоу, тэмцээн, • Асуулт хариултын булан • Мэргэжилтний зөвлөгөө, • Эссе, гар зургийн уралдаан, • Санамж • Зурагт хуудас 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн багш • Биеийн тамирын арга зүйч • Нийгмийн ажилтан • Үе тэнгийн сургагч • Сайн дурын идэвхтэн • Урлаг, спортын одод • Шийдвэр гаргагчид • Хамт олон
		<ul style="list-style-type: none"> • Шийдвэр гаргагчдад 	<ul style="list-style-type: none"> • Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин бүрдүүлэх • Ажлын байран дээр идэвхтэй 	<ul style="list-style-type: none"> • Ажлын байр • Сурталчилгааны материал 	<ul style="list-style-type: none"> • Ухуулга нөлөөлөл • Мэдээллийн багц • Уулзалт, ярилцлага 	<ul style="list-style-type: none"> • Хамт олон • Эрүүл мэндийн ажилтан

			хөдөлгөөнийг дэмжих			
Тамхи татахгүй байх	Тамхины хор хөнөөлийн талаар мэдээлэл авсан хүүхэд, залуучуудын тоо Тамхинаас гарах хүсэл төрсөн хүний тоо Тамхинаас гарах алхам хийсэн хүний тоо Тамхинаас гарахаар мэргэжлийн байгууллагад хандсан хүний тоо	<ul style="list-style-type: none"> 15-24 охид, хөвгүүд, залуучууд 	<ul style="list-style-type: none"> Тамхины хор уршгийн талаар Тамхи татахгүй байх Тамхинаас татгалзах Тамхинаас гарах 	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн хичээл Телевиз, радио Интернет Комикс Кино театр, Нийтийн тээврийн хэрэгсэл, Тоглоомын газар Эрүүл мэндийн өдөрлөг Үсчин Сурталчилгааны материал 	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн сурах бичиг Бүлгийн ярилцлага Бусдын туршлагыг яриулах Реалити шоу, тэмцээн, Мэргэжилтний зөвлөгөө, Эссе, гар зургийн уралдаан, Санамж Зурагт хуудас 	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн хичээлийн багш Хамт олон Эрүүл мэндийн ажилтан Сайн дурын идэвхтэн Урлаг, спортын одод Үе тэнгийн сургагч Сургуулийн удирдлага Тамхинаас гарахыг дэмжих бүлэг
		<ul style="list-style-type: none"> 35-аас дээш насныханд 				
		<ul style="list-style-type: none"> Шийдвэр гаргагчдад 	<ul style="list-style-type: none"> Тамхигүй орчин бүрдүүлэх Тамхины эрэлтийг бууруулах үнийн бодлого хэрэгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> Ажлын байр Сурталчилгааны материал 	<ul style="list-style-type: none"> Ухуулга нөлөөлөл Мэдээллийн багц Уулзалт, ярилцлага 	<ul style="list-style-type: none"> Хамт олон Эрүүл мэндийн ажилтан
		<ul style="list-style-type: none"> 15-24 насны 		<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн 	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн 	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн

<p>Архи, согтууруулах ундаа хэрэглэхээс татгалзах</p>	<p>Архины хор уршгийн талаар мэдээлэл авсан хүүхэд, залуучуудын тоо Архины хор холбогдлын талаар мэдээлэл сонссон хүмүүсийн тоо Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийн тоо Архинаас гарах алхам хийсэн хүний тоо</p>	<p>залуучууд, тэр дундаа ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, их, дээд сургуулийн оюутнууд</p>	<ul style="list-style-type: none"> • Архины хор уршгийн талаар • Архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх • Архи, согтууруулах ундаа хэрэглэхээс татгалзах • Архинаас гарах 	<p>хичээл</p> <ul style="list-style-type: none"> • Телевиз, радио • Интернет • Комикс • Фитнесс, боди клубууд, • Кино театр • Танилцах үдэшлэг • Сурталчилгааны материал 	<p>сурах бичиг</p> <ul style="list-style-type: none"> • Реалити шоу, тэмцээн • Асуулт хариултын булан • Мэргэжилтний зөвлөгөө, • Эссе, гар зургийн уралдаан • Санамж • Зурагт хуудас 	<p>хичээлийн багш</p> <ul style="list-style-type: none"> • Бахархан дуурайдаг хүмүүс • Сэтгэц, наркологийн эмч • Сайн дурын ажилтан • Эцэг, эхчүүд • Үе тэнгийн сургагч • Архинаас гарахыг дэмжих бүлэг
		<ul style="list-style-type: none"> • 25-54 насны эрчүүд • 35-54 насны эмэгтэйчүүд 	<ul style="list-style-type: none"> • Ажлын байр • Сонин сэтгүүл • Телевиз, радио • Интернет • Үсчин, гоо сайхан 	<ul style="list-style-type: none"> • Ажлын байран дахь сургалт • Асуулт, хариултын булан • Ярилцлага • Эрүүл мэндийн цуврал нэвтрүүлэг • Ганцаарчилсан зөвөлгөө 	<ul style="list-style-type: none"> • Сэтгэц, наркологийн эмч • Үе тэнгийн сургагч • Хамт олон • Хэвлэл мэдээллийнхэн • ТББ 	
		<ul style="list-style-type: none"> • Шийдвэр гаргагчдад 	<ul style="list-style-type: none"> • Архигүй хамт олон болох хөдөлгөөн өрнүүлэх • Архины эрэлтийг бууруулах үнийн бодлого хэрэгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Ажлын байр • Сурталчилгааны материал 	<ul style="list-style-type: none"> • Ухуулга нөлөөлөл • Мэдээллийн багц • Уулзалт, ярилцлага 	<ul style="list-style-type: none"> • Хамт олон • Эрүүл мэндийн ажилтан

Сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах ур чадварт сурах	Бухимдлаа зөв тайлах талаар сонссон хүмүүсийн тоо Бухимдлаа зөв тайлах алхам хийж буй хүмүүсийн тоо Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн хүний тоо Компьютер тоглоомын донтолтоос гарах алхам хийсэн хүүхдийн тоо Баг, хорооны дэргэд байгуулсан сайн дурын бүлгэм, багийн тоо Настны сэтгэл гутралаас сэргийлэх талаар мэдээлэл авсан өндөр настны тоо	<ul style="list-style-type: none"> • Нийт хүн ам 	<ul style="list-style-type: none"> • Бухимдлыг архи, тамхиар тайлахгүй байх • Бухимдал зөв тайлах аргад сурах 	<ul style="list-style-type: none"> • Сургууль, ажлын байр • Бясалгалын төв • Шашны байгууллага • Телевиз, радио • Сонин, сэтгүүл • Интернет • Фитнесс, боди клуб • Эрүүл мэндийн өдөрлөг • Үсчин, гоо сайхны газар • Сурталчилгааны материал 	<ul style="list-style-type: none"> • Сургалт Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага • Асуулт хариултын булан • Мэргэжилтний зөвлөгөө • Хэлэлцүүлэг • Ярилцлага • Бусдын туршлагыг яриулах • Санамж • Зурагт хуудас 	<ul style="list-style-type: none"> • Сэтгэл зүйчид • Зөвөлгөө өгөх төвийн ажилтан • эрүүл мэндийн ажилтан • үе тэнгийнхэн • найз нөхөд, багш нар • Сайн дурын идэвхтэн • Сэтгэц, наркологийн эмч
		<ul style="list-style-type: none"> • Хүүхэд, залуучууд 	<ul style="list-style-type: none"> • Компьютер тоглоомд донтохгүй байх • Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөж сурах 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн хичээл • Комикс • Зөвөлгөө өгөх төв 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн сурах бичиг • Цуврал өгүүллэгүүд • Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн багш • Сэтгэц, наркологийн эмч
		<ul style="list-style-type: none"> • Өндөр настан 	<ul style="list-style-type: none"> • Сэтгэл гутралаас сэргийлэх 	<ul style="list-style-type: none"> • Өндөр настны кабинет • Оршин суугаа баг, хороо • Сайн дурын бүлгэм • Сурталчилгааны материал 	<ul style="list-style-type: none"> • Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага • Зөвөлгөө, асуулт хариултын булан • Санамж 	<ul style="list-style-type: none"> • Өндөр настны эмч • Оршин суугаа баг, хорооны сайн дурын идэвхтэн
Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлээр:						

<p>Замын хөдөлгөөний дүрмийг баримтлах</p>	<p>Замын хөдөлгөөний дүрмийн талаар мэдээлэл авсан хүний тоо Зам тээврийн осол гэмтлээс сэргийлэх үйл ажиллагаад оролцсон хүмүүсийн тоо</p>	<ul style="list-style-type: none"> • Нийт хүн ам 	<ul style="list-style-type: none"> • Ногоон гэрэл, Цагаан шугамаар гарах • Суудлын бүсээ зүүх • Хурд хэтрүүлэхгүй байх • Хүүхэддээ хамгаалалтын суудал хэрэглэх • Машины бүрэн бүтэн байдлыг шалгах • Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх 	<ul style="list-style-type: none"> • Телевиз, радио • Сонин, сэтгүүл • Эрүүл мэндийн хичээл • Интернет • Гар утас • Зарлалын LED дэлгэц, • Нийтийн тээврийн хэрэгсэл, автобусны буудлуудын мэдээллийн самбар, • Үйлчилгээний газруудын гадна хана • Машин угаалгын газар • Эрүүл мэндийн өдөрлөг • Сурталчилгааны материал 	<ul style="list-style-type: none"> • Цуврал нэвтрүүлэг • Хэлэлцүүлэг • Ярилцлага • Сургамжит үйл явдал, Бусдын туршлагыг яриулах • Асуулт хариултын булан • Эрүүл мэндийн сурах бичиг • Санамж • Зурагт хуудас • Наалт 	<ul style="list-style-type: none"> • Хэвлэл, мэдээллийнхэн • Эрүүл мэндийн ажилтан • Замын цагдаагийн ажилтан • Эрүүл мэндийн багш • Сайн дурын идэвхтэн • Нийгмийн ажилтан • Үе тэнгийн сургагч • Баг, хорооны идэвхтэн
<p>Ахуйн осол гэмтлээс сэргийлэх</p>	<p>Түлэгдэлтээс урьдчилан сэргийлэх мэдээлэл авсан 0-5 насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн тоо Ахуйн осол гэмтлээс сэргийлэх талаар мэдээлэл авсан хүний тоо</p>	<ul style="list-style-type: none"> • Эцэг эх, ах эгч • Цэцэрлэг, яслийн багш • Бага насны хүүхэд • Эрүүл мэндийн ажилтан • Сайн дурын ажилтан 	<ul style="list-style-type: none"> • Халуун хоол цайг хүүхдээс хол тавих • Хүүхдийг усанд оруулахдаа эхлээд хүйтэн усаа хийгээд, дараа нь халуун усыг хийх • Хүүхдээ гал болон тэсэрч дэлбэрэх тоглоомоор тоглуулахгүй 	<ul style="list-style-type: none"> • Сургууль, цэцэрлэг, яслийн эрүүл мэндийн хичээл • Сургалт • Эрүүл мэндийн газар • Телевиз, радио • Сонин, сэтгүүл • Сурталчилгааны материал 	<ul style="list-style-type: none"> • Жүжигчилсэн тоглолт • Хүүхэлдэйн кино • Эцэг, эхчүүдэд сургалт явуулах • Санамж • ТҮ, Радиогийн сэрэмжлүүлэг • Зурагт хуудас • Гарын авлага 	<ul style="list-style-type: none"> • Эцэг эх, ах эгч • Сургууль, цэцэрлэг, яслийн багш • Сайн дурын идэвхтэн • Эрүүл мэндийн ажилтан • Хэвлэл, мэдээллийнхэн

			<p>байх</p> <ul style="list-style-type: none"> • Бага насны хүүхдийг гэрт нь насанд хүрсэн асран хамгаалагчгүйгээр цоожлон орхихгүй байх • Бага насны хүүхдүүдийг насанд нь тохироогүй тоглоом, спортын хэрэгслээр тоглуулахгүй байх 			
--	--	--	--	--	--	--

НҮЭМ-ийн эрүүл зан үйлийг төлөвшүүлэх МСС-г эрчимжүүлэх Зорилт 4-ийн хүрээнд:

Жирэмсний хяналтад эрт хамрагдах	Жирэмсний эрт хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо Жирэмсний үед эрт илрүүлсэн хүндрэлийн тоо	<ul style="list-style-type: none"> • Жирэмсэн эмэгтэйчүүд • НҮ-н насны эмэгтэйчүүд • Бүртгэлгүй жирэмсэн эмэгтэйчүүд 	<ul style="list-style-type: none"> • Жирэмсний хяналтад эрт хамрагдах • Жирэмсний буюу төрөхийн өмнөх тусламж үйлчилгээнд хамрагдах • Та жирэмсний эхний 3 сарын дотор хяналтад орох. 	<ul style="list-style-type: none"> • Баг хороо • Өрхийн эмнэлэг • Нийгмийн халамж, үйлчилгээний газар • НҮЭМ-ийн кабинет • Эмэгтэйчүүд олноор ажилладаг байгууллагууд • Сурталчилгааны материал 	<ul style="list-style-type: none"> • Ганцаарчилсан болон гэр бүлийн хүнтэй нь хамт зөвөлгөө өгөх • Сургалт • Санамж • Зурагт хуудас 	<ul style="list-style-type: none"> • Баг, хороо, өрхийн эмнэлгийн нийгмийн ажилтан, сувилагч • НҮЭМ-ийн кабинетийн эмч • Сайн дурын идэвхтэн • Үе тэнгийн сургагч
----------------------------------	---	---	--	---	---	---

<p>Эх нярайд илрэх аюултай шинжийг мэдэн, урьдчилан сэргийлэх</p>	<p>Эх нярайд илрэх аюултай шинжийг мэддэг нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тоо Эх нярайд илрэх аюултай шинжийг мэдэж эмнэлэгт хандсан эцэг, эхчүүдийн тоо</p>	<ul style="list-style-type: none"> • Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд эрэгтэйчүүд 	<p>Эх, нярайд илрэх аюултай шинжийг мэдэх Эх, нярайд илрэх аюултай шинжийг мэдэн эмнэлэгт эрт хандах</p>	<ul style="list-style-type: none"> • НҮЭМ-ийн кабинет • Төрөх тасаг • Баг хороо • Өрхийн эмнэлэг • Нийгмийн халамж, үйлчилгээний газар 	<ul style="list-style-type: none"> • Мэргэжилтний зөвлөгөө өгөх • Сургалтад хамруулах • Санамж • Зурагт хуудас • Ярилцлага /гэр бүлтэй нь хамт/ 	<ul style="list-style-type: none"> • НҮЭМ-ийн кабинетийн эмч • Төрөх тасгийн эмч, сувилагч • Баг, хороо, өрхийн нийгмийн ажилтан • Сайн дурын идэвхтэн
<p>Гэр бүл төлөвлөлтийн үр дүнтэй аргуудыг хэрэглэх</p>	<p>Гэр бүл төлөвлөлтийн орчин үеийн аргын хэрэглээний хувь Орчин үеийн жирэмсэлтээс хамгаалах аргуудын талаар дор хаяж 3 аргыг мэддэг хүмүүсийн тоо</p>	<ul style="list-style-type: none"> • Нөхөн үржихүйн насны эмэгтэйтэйчүүд • Нөхөр/хамт ран амьдрагчид 	<ul style="list-style-type: none"> • Жирэмслэхээс хамгаалах аргуудыг зааврын дагуу зөв хэрэглэх • Гэр бүлээ зөв төлөвлөх • ЖХАХ-ийн талаарх буруу, ташаа мэдээллүүдийг няцаах, тайлбарлах • Үр хөндөлтөөс сэргийлэх 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн хичээл • НҮЭМ-ийн кабинет • Өсвөр үеийн зөвлөгөө өгөх төвүүд • Өрхийн эмнэлэг • Сурталчилгааны материал 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн сурах бичиг • Эрүүл мэндийн зөвлөгөө • Чин сэтгэлийн яриа • Үе тэнгийн сургагч бэлтгэх Санамж, зөвлөмж 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн хичээлийн багш • Эрүүл мэндийн ажилтан • Үе тэнгийн сургагч

<p>Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах</p>	<p>Хөхөө өөрөө шалгадаг мэдлэгтэй 30- аас дээш насны эмэгтэйчүүдийн тоо ХХВ-ийн вакцинд хамрагдсан охидын тоо Умайн хүзүүний эрт илрүүлэлтийн шинжилгээнд хамрагдагсдын тоо Хөхний хавдрын эрт илрүүлэлтийн шинжилгээнд хамрагдагсдын тоо</p>	<ul style="list-style-type: none"> • 10-14 насны охид • 15-64 насны хүн ам • 30-аас дээш насны эмэгтэйчүүд 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт эрт орох • Эмээ, ээж, эгч, эмэгтэй дүүгээ хавдраас урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах • Хөхөө өөрсдөө шалгаж сурах . 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн хичээл • НҮЭМ-ийн кабинет • Хавдар судлалын төв • Хавдрын кабинет • Өсвөр үеийн зөвөлгөө өгөх төвүүд • Анхан шатны эмнэлэг • Сурталчилгааны материал • Сургалт 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн сурах бичиг • Эрүүл мэндийн зөвлөгөө • Чин сэтгэлийн яриа • Үе тэнгийн сургагч бэлтгэх 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн хичээлийн багш • Эрүүл мэндийн ажилтан • Үе тэнгийн сургагч
---	---	---	---	---	---	---